

ШАРГА СУМД 2017 ОНЫ 12 САРД БОЛСОН  
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС...

**ОНЫ ШИЛДЭГ 9 АЛДАРТАН ТОДОРЛОО**

Сумын ИТХ-аас баталсан журмын дагуу оны шилдгүүдээ шалгарууллаа. Энэ оны

- Шилдэг бөх-Б.Төрмөнх
- Шилдэг уяач Ц.Дүүрэнбаяр
- Шилдэг малчин С.Дашцэрэн
- Шилдэг ажилтан Э.Тогтбаатар
- Шилдэг сурагч Б.Дашдаваа
- Шилдэг залуу Б.Шинэхүү
- Шилдэг төрийн албан хаагч Г.Болормаа
- Шилдэг тариаланч Б.Баатар
- Шилдэг өрх-М.Золбаяр нар шалгарлаа.

**МАЛ 3 ТӨРӨЛ ДЭЭРЭЭ ӨСЛӨӨ**

Энэ онд мал тооллогоор 171439 толгой мал тоологдож өмнөх оноос 9756 малаар өссөн байна. Сумын хэмжээнд 5419 Тэмээ, 5691 Адуу, 5863 Үхэр, 35100 Хонь, 119366 тоологдсон байна. Хамгийн олон малыг Улаантуг баг тоолуулсан байна.

Хамгийн олон тэмээгээр Б.Дашмягмар, адуугаар Г.Ган-Очир, Үхрээр Г.Ган-Очир, хониор Т.Лувсандорж, ямаагаар Д.Гаадансүрэн нар тэргүүлж байна.

Энэ жил 15 мянгат малчин шинээр төрлөө.

**ТЭМЭЭНИЙ БАЯР БОЛЛОО**

Тэмээн сургийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор тэмээний баярыг жил бүр зохион байгуулж байгаа. Энэ удаагийн тэмээний баярт хурдан ат, хурдан тором, сайхан ат, ингэ шалгаруулах, буйл зорох, бурантаг томох тэмцээнийг зохион байгууллаа. Тэмээний баярт Чандмань, Бигэр, Тайшир, Төгрөг, Баян-Уул, Дарив, Халиун сумдын тэмээчид оролцсон өргөн наадам болсон. Тэмээний баярыг аймгийн аварга малчин Г.Ган-Очир, Н.Гантулга Х.Бадрах, сумын аварга малчин Ц.Ганболд, Б.Баасандорж нар ивээн тэтгэж явууллаа. Тэмээний баярыг шилдэг тэмээчнээр Чандмань сумын тэмээчин Барсболд тодорлоо.

Мэдээлэл бэлтгэсэн:Д.Ончимэг